

**ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ЭД ХӨРӨНГИЙН ХАРИУЦЛАГЫН
ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХЭСЭГЧЛЭН
ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ**

Улаанбаатар хот
2026 он

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	3
УДИРТГАЛ	4
НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	6
1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох	6
1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох	7
1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл	7
1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэрийг сонгох	8
1.5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох	9
1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох	100
ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ	100
ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ	111
3.1. “ЗОРИЛГОД ХҮРСЭН ТҮВШИН” ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮРЭЭНД ҮНЭЛСЭН БАЙДАЛ	
3.2. “ПРАКТИКТ НИЙЦЭЖ БАЙГАА БАЙДАЛ” ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮРЭЭНД ҮНЭЛСЭН БАЙДАЛ	
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, САНАЛ	13

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ЦАХ	Цэргийн алба хаагч
МУБХтХ	Монгол Улсын батлан хамгаалах тухай хууль
ЗХтХ	Зэвсэгт хүчний тухай хууль
ЦАтХ	Цэргийн албаны тухай хууль
ЦАХЭХХтХ	Цэргийн алба хаагчийн эд хөрөнгийн хариуцлагын тухай хууль
БХЯ	Батлан хамгаалах яам
ЗХЖШ	Зэвсэгт хүчний Жанжин штаб
ЦЭХБХ	Цэргийн эд хөрөнгийн бүрэн хариуцлага
ЦЭХХХ	Цэргийн эд хөрөнгийн хязгаарлагдмал хариуцлага

УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-т төрийн нийтийн өмчийн зохицуулалтыг тодорхой болгохоор зааж, 1.2.6-д “төрийн нийтийн өмчийг зохистой ашиглах, зарцуулахад тавих хяналтыг боловсронгуй болгох.” гэж, мөн оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “АЛСЫН ХАРАА-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын Зорилт 4.1-д “2.Төсвийн хөрөнгийг эдийн засаг, нийгмийн хөгжилд чиглүүлсэн, үр ашигтай, хариуцлагатай төсөв, санхүүгийн тогтолцоотой болсон байна.”, Зорилт 5.4-т “3.Төрийн албанд ёс зүй, сахилга хариуцлагын оновчтой тогтолцоо бүрдэж, ёс зүйтэй төрийн алба төлөвшинө.”, мөн тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны зорилтын 4.1.3-т “Болзошгүй өр төлбөрийн төсөвт үзүүлэх нөлөөллийг үнэлж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог хөгжүүлнэ.”, 5.6.3-т “Төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, хариуцлагатай байдлыг хангах, хяналт тавих зохицуулалтыг боловсронгуй болгоно.” гэж тус тус тусгагджээ.

Улмаар УИХ-ын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.3.10-т “Батлан хамгаалах материаллаг нөөцийг бүрдүүлэх, түүний хадгалалт, хамгаалалтыг сайжруулах шат дараатай арга хэмжээг хэрэгжүүлнэ.” гэж заасны хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 77-д “Цэргийн алба хаагчийн эд хөрөнгийн хариуцлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” гэж заасныг үндэслэн Батлан хамгаалах сайдын 2025 оны 1а/4537 дугаар албан бичгээр “Цэргийн алба хаагчийн эд хөрөнгийн хариуцлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулахыг чиглэл болгосон.

Монгол Улсын Үндсэн хууль 1992 онд батлагдаж, нийгэм, эдийн засаг, зах зээлийн шилжилттэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын 1998 оны 56 дугаар тогтоолын хавсралтаар “Монгол Улсын Төрийн цэргийн бодлогын үндэс” баримт бичгийг, 1996 онд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг баталж, тэдгээрт нийцүүлэн 2002 онд Цэргийн алба хаагчийн эд хөрөнгийн хариуцлагын тухай хуулийг 4 бүлэг, 13 зүйл, 11 заалттайгаар баталснаар цэргийн эд хөрөнгийн хариуцлагын тогтолцоо, эрх зүйн үндэс бүрджээ.

Цэргийн алба хаагчийн эд хөрөнгийн хариуцлагын тухай хууль нь шилжилтийн үеийн өмч хөрөнгийн талаарх төрийн байгууллагын эрх хэмжээг тогтоон зохицуулахаас илүүтэй цэргийн эд хөрөнгөд хохирол учруулсан цэргийн алба хаагчид эд хөрөнгийн хуулийн хариуцлага хүлээлгэхэд чиглэсэн байдаг.

Цэргийн алба хаагчийн эд хөрөнгийн хариуцлагын тухай хууль нь Монгол Улсын төр, засгаас төрийн өмч хөрөнгийн талаар баримталж буй бодлого, нийгэм, эдийн засгийн харилцааны өөрчлөлт, шинэчлэлттэй нийцэхгүй байгаа бөгөөд батлан хамгаалах хууль, эрх зүйн орчны өөрчлөлт, шинэчлэлд төдийлөн нийцэхгүй байна.

Энэ хүрээнд цэргийн алба хаагчийн эд хөрөнгийн хариуцлагын тогтолцооны шинэчлэлийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Цэргийн алба хаагчийн эд хөрөнгийн хариуцлагын тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэх зайлшгүй шаардлагатай байна. Ингэснээр уг хуулийн хэрэгжилтийн бодит байдалд дүн

шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээл, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх боломжтой.

Иймд Зэвсэгт хүчний Жанжин штабаас Цэргийн алба хаагчийн эд хөрөнгийн хариуцлагын тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаварт тус тус үнэлгээг хийлээ.

Харин энэхүү судалгаагаар Цэргийн алба хаагчийн эд хөрөнгийн хариуцлагын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ыг баримтлан хэсэгчлэн үнэлгээ хийж, судалгааны тайланг боловсрууллаа.

Тус судалгааны зорилго нь хуулийн хэрэгжилтийн явц дахь хүндрэл, бэрхшээл, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэн, цаашид зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлж, үнэлэлт дүгнэлт өгөх, зөвлөмж боловсруулахад оршино.

НЭГ.ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

ЦАХЭХХТХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн гурван үе шаттайгаар хийж гүйцэтгэсэн. Төлөвлөх үе шатанд дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:

1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
4. Харьцуулах хэлбэрийг сонгох;
5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох;
6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.

Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох

ЦАХЭХХТХ нь 2002 оны 06 дугаар сарын 13-ны өдөр батлагдаж, 2002 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж эхэлсэн байна. Тус хууль батлагдсанаас хойш нэмэлт, өөрчлөлт ороогүй бөгөөд мөн адил хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийгдээгүй байна.

ЦАХЭХХТХ хэрэгжиж эхлээд 24 жилийн хугацаа өнгөрч байгаа боловч тус хуулийн зарим зохицуулалтыг практикт нэг мөр ойлгон хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, олон нийтээс тус хуультай холбоотой санал, шүүмж ирсээр байна.

Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3-т “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно” гэж, мөн “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан батлан хамгаалах материаллаг нөөцийг бүрдүүлэх, түүний хадгалалт, хамгаалалтыг сайжруулах эрх зүйн орчны шинэчлэлийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийн хэрэгжилтийг үнэлэх, түүнчлэн цэргийн эд хөрөнгийн хариуцлагын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй хүндрэл, бэрхшээл, цэргийн байгууллага болон ЦАХ-ийн эд хөрөнгийн хариуцлага хүлээсэн ЦАХ хооронд маргаан үүсгэж буй асуудал болон ЗХЖШ, төрлийн цэргийн командлал, удирдах газрын дунд зохион байгуулсан хэлэлцүүлэг, санал, асуулгын үр дүнд үндэслэн ЦАХЭХХТХ-д үнэлгээ хийх зайлшгүй шаардлага бий болсон гэж үзэж байна.

Мөн тус хуулийн зарим зүйл, заалтын хувьд аргачлалын 3.2-т заасан ойлгомжгүй, зөрчилтэй зохицуулалттай байх, тэдгээр нь цаашид тухайн харилцаанд сөрөг үр дагавар үүсгэх шинжтэй, практикт хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, бодит байдалтай нийцээгүй, тухайн харилцааг зохицуулах боломжгүй нөхцөл байдал үүссэн талаар олон нийтээс үндэслэл бүхий саналууд ирсээр байна.

Тус хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийснээр цэргийн эд хөрөнгийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийн бодит байдал, хуулийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгах, хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид зохистой, үр дүнтэй хэрэгжих, хэрэгжүүлэх хувилбарыг тодорхойлох боломж бүрдэнэ. Өөрөөр хэлбэл, хуулиар зохицуулсан

харилцаа нь зорилгодоо хүрсэн эсэх болон практик хэрэгжилтийг судлан хуулийн хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоо оновчтой байгаа эсэх, хариуцлагын тогтолцоо үүргээ гүйцэтгэж байгаа эсэх, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах эсвэл шинэчлэн батлах шаардлага бий эсэхийг тогтоох боломжтой.

1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох

Үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэдэг. Өөрөөр хэлбэл, үнэлгээ хийх болсон шалтгаан (өмнө тодорхойлсон)-тай харилцан уялдаа, хамааралтайгаар хийгдэх ажиллагаа бөгөөд тодорхойлогдсон эерэг, сөрөг нөхцөл байдал, хүндрэл бэрхшээл, тулгамдсан асуудал, үр дагавар бүхий харилцаатай холбогдсон хуулийн зохицуулалтыг илрүүлнэ.

Үнэлгээний хүрээг тогтоохдоо үнэлгээ хийх ажлын төлөвлөлт, зохион байгуулалт, хүний нөөц, цаг хугацаа, гарах зардлыг заавал харгалзан үзэх нь чухал. Хуулийг бүхэлд нь үнэлэх ажиллагааны зардал ихэвчлэн хэт өндөр гардаг тул зөвхөн тухайн хуулийн зорилго, үнэлгээний шалгуурт хамгийн ихээр нөлөөлж болохуйц хуулийн зохицуулалтыг зөв сонгох шаардлагатай.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 51.4 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн зохицуулах харилцааны онцлог, асуудлаас хамааран хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийхдээ хууль тогтоомжид бүхэлд нь эсхүл түүний зарим зүйл, хэсэг, заалтыг сонгож болно” гэж заасны дагуу ЦАХЭХХТХ-ийн практикт хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, маргаан дагуулж буй эрх зүйн хийдэл, давхардал, хоёрдмол утгатай, иргэд, ЦАХ-дын зүгээс шүүмжлэл дагуулж буй зохицуулалтуудыг сонгон авах нь зүйтэй хэмээн үзсэн болно. Энэ хүрээнд тус ЦАХ-д эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл, ЦАХЭХБХ болон ЦАХЭХХХ-тай холбоотой зохицуулалтыг сонгон авч судлан үзлээ.

1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

“Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу дээрх хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг баримталж, мөн үнэлгээний хүрээ, онцлогоос хамааран дараах шалгуур үзүүлэлтийг сонгосон болно. Үүнд:

1. “Зорилгод хүрсэн түвшин”
2. “Практикт нийцэж байгаа байдал”

1.3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

ЦАХЭХХТХ-ийн 1 дүгээр зүйлд тус хуулийн зорилгыг “...цэргийн жинхэнэ алба хаагч, дайчилгаатай сургууль, цугларалтад оролцож байгаа цэргийн үүрэгтэн болон цэргийн сургуулийн сонсогч /цаашид “цэргийн алба хаагч” гэх/-д эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино...” гэж тодорхойлжээ. Иймд тус хуулийн дээр дурдсан зорилгыг хангахад чиглэсэн зүйл, заалтуудыг сонгож “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлгээг хийлээ. Сонгосон зүйл, заалтыг хүснэгтээр үзүүлбэл:

**Хүснэгт 1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд
сонгосон зүйл, заалтууд**

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
1.	5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэг	5.4.Цэргийн алба хаагчийн буруутай үйлдэл /эс үйлдэхүй/-ийн улмаас гуравдагч этгээдэд учирсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу цэргийн анги, байгууллага төлсөн тохиолдолд гарсан зардлыг гэм буруутай цэргийн алба хаагч энэ хуульд заасан журмын дагуу барагдуулна.

1.3.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Энэхүү шалгуур үзүүлэлт нь тухайн хууль тогтоомжийн зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг, сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл гарч байгаа эсэхийг тодорхойлоход чиглэгддэг. Иймд судалгааны энэ хэсэгт тус хуулийн зарим зохицуулалтыг сонгож, уг зүйл, заалт практикт хэрхэн хэрэгжиж байгаа байдал, түүний эерэг болон сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл, бэрхшээл байгаа эсэхийг тодорхойлохыг зорьсон болно. Сонгосон зүйл, заалтыг хүснэгтээр үзүүлбэл:

**Хүснэгт 2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд
сонгосон зүйл, заалтууд**

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
1.	8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг	8.2.Тусгай зориулалтын болон зах зээлийн үнийг нь тодорхойлох боломжгүй эд хөрөнгийн үнийг батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан тусгай зориулалтын цэргийн эд хөрөнгийн үнийн жагсаалтад туссанаар, хэрэв уг жагсаалтад тусаагүй бол нягтлан бодох бүртгэлд туссан өртгөөр тодорхойлно.
2	10 дугаар зүйлийн 10.5, 10.7 дахь хэсэг	10.5.Эд хөрөнгийн хариуцлага хүлээсэн цэргийн алба хаагч цэргээс халагдах, чөлөөнд гарах, цугларалт дуусах үед төлбөрөө төлж дуусаагүй бол үлдсэн төлбөрийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль тогтоомжид заасны дагуу төлүүлнэ. 10.7.Шүүх болон цэргийн анги, байгууллагын захирагч /дарга/ хохирол учирсан нөхцөл байдал, гэм буруугийн хэр хэмжээ болон цэргийн алба хаагчийн эд хөрөнгийн байдлыг харгалзан нөхөн төлөх төлбөрийн хэмжээг багасгаж болно.

1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэрийг сонгох

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ үнэлэх болсон шалтгаан, үнэлгээний хүрээ, шалгуур үзүүлэлт зэргийг харгалзан дор дурдсан харьцуулах хэлбэрүүдээс сонгоно. Үүнд:

- Байх ёстой болон одоо байгаа;
- Хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойших;
- Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших;
- Тохиолдол судлах.

Хүснэгт 3. “Үнэлгээний харьцуулах хэлбэрийн тайлбар”

№	Харьцуулах хэлбэр	Ойлголт, онцлог
1.	Байх ёстой болон одоо байгаа	Хуулиар тогтоосон “байх ёстой” үзүүлэлт практикт хэр байгааг илрүүлэх зорилготой. Үнэлгээ хийх хуульд байвал зохих тодорхой абсолют үзүүлэлтийг зааж өгсөн тохиолдолд одоо бодит байгаа үзүүлэлттэй харьцуулна.
2.	Хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойш	Хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнөх нөхцөл байдлыг хууль хүчин төгөлдөр хэрэгжсэний дараах буюу хуулийн хэрэгжилтийн явцад гарч буй үр дагавартай харьцуулна.
3.	Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш	Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөнийг он дарааллаар тогтоон харьцуулна.
4.	Тохиолдол судлах	Хууль, эсхүл үнэлгээний хүрээгээр тогтоогдсон зүйл, заалт өөр орчин нөхцөлд (бусад улсад, өөр орон нутагт гэх зэрэг) хэрхэн хэрэгжиж буй байдлыг харьцуулна.

Судалгааны явцад ЦАХЭХХТХ-ийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхдээ байх ёстой болон одоо байгаа, хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойших, хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших, тохиолдол судлах харьцуулах хэлбэрийг аль тохирохыг ашиглана. Мөн гадаад орнуудын эрх зүйн зохицуулалт, сайн туршлагыг харьцуулан судална.

Судалгааны явцад хууль тогтоомжоос сонгон авсан зохицуулалтын “байх ёстой” үзүүлэлт практикт хэр байгааг илрүүлэхэд буюу хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнөх нөхцөл байдлыг хууль хүчин төгөлдөр хэрэгжсэний дараах буюу хуулийн хэрэгжилтийн явцад гарч буй үр дагавартай харьцуулах харьцуулалтын хэлбэрийг ашиглав.

1.5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох

Шалгуур үзүүлэлтийг томьёолохдоо сонгосон шалгуур үзүүлэлт тус бүрээр ЦАХЭХХТХ-ийн сонгон авсан зүйл, хэсэг, заалтад тохируулан дараах таамаглал дэвшүүлж, асуулт боловсрууллаа:

Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. ЦАХЭХХТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан учирсан хохирлыг гуравдагч этгээдэд төлсөн тохиолдолд гарсан зардлыг гэм буруутай ЦАХ-аар барагдуулахтай холбоотой зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх.

Практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. ЦАХЭХХТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.5-д заасан ЦАХ-ийн төлж дуусаагүй төлбөрийг шүүхийн журмаар төлүүлэх зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна бэ?

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 2. ЦАХЭХТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.7-д заасан учирсан нөхцөл байдал, гэм буруугийн хэр хэмжээ болон эд хөрөнгийн байдлыг харгалзан шүүх болон цэргийн ангийн захирагч нөхөн төлөх төлбөрийн хэмжээг багасгахтай холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Тус зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх.

1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Уг үнэлгээний ажилд анхдагч болон хоёрдогч эх сурвалжуудыг хамтатган ашигласан бөгөөд үнэлгээний хүрээнээс хамаарч өөр хоорондоо ялгаатай мэдээллийг ашигласан болно. Хоёрдогч эх сурвалжаар холбогдох хууль тогтоомж, онолын үндэслэл, цэргийн байгууллага болон ЦАХ-аас хуулийг хэрэгжүүлэхэд үүсдэг тулгамдсан асуудал, хүндрэл, бэрхшээлийг хэлэлцүүлэг, санал асуулгаар тодорхойлсон үр дүн, ЗХЖШ-ын Ахмадын хороо болон салбарын эрдэмтэн, судлаачидтай хийсэн уулзалт, хэлэлцүүлэг, өмч хамгаалах зөвлөл болон шүүхийн шийдвэр зэрэг мэдээллийг ашигласан болно.

Мэдээлэл цуглуулах арга:

- Байгаа мэдээллийг цуглуулж ашиглах;
- Холбогдох субъектээс судалгаа авах аргыг сонгон хэрэгжүүллээ.

Байгаа мэдээллийг цуглуулах хүрээнд: Энэ аргын хүрээнд ЦАХЭХТХ (2002 он), түүний үзэл баримтлал, уг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтад заасан санхүүгийн тайлан бүртгэл, 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт заасан нягтлан бодох бүртгэл, 9 дүгээр зүйлийн 9.1, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасан шалгалтын дүн, цэргийн албанаас чөлөөлөгдсөн болон халагдсан бүрэлдэхүүнтэй хийсэн эд хөрөнгийн тооцоо, сургалтын төлбөрийн судалгаа, эд хөрөнгийн тооллогын дүн, эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэсэн судалгаа, санхүүгийн хяналтын чиглэлээр явуулсан төлбөр, зөрчлийн судалгаа;

Холбогдох субъектээс судалгаа авах хүрээнд: Энэ аргын хүрээнд эрх зүйн зохицуулалтыг хэрэгжүүлэх явцад тулгамдаж буй асуудлыг илрүүлэхийн тулд ЗХЖШ, төрлийн цэргийн командлал, удирдах газрын хэмжээнд хийсэн хэлэлцүүлэг, уулзалт хийж, холбогдох байгууллагаас үйл ажиллагааны тайлан, судалгаа, бусад мэдээллийг гаргуулан авч үнэлгээ хийхэд ашиглав.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Хэрэгжүүлэх үе шатны гол зорилго нь хэрэгцээтэй, шаардлагатай байгаа ач холбогдол бүхий мэдээллийг цуглуулан судалснаар хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгах, түүний хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид тухайн хууль тогтоомжийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлох юм.

ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ

- Монгол Улсын батлан хамгаалах тухай хууль
- Зэвсэгт хүчний тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

- Цэргийн алба хаагчийн эд хөрөнгийн хариуцлагын тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого;
- Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр.

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

ЦАХЭХХтХ нь 2002 оны 06 дугаар сарын 13-ны өдөр батлагдаж, 2002 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж эхэлсэн. Хэрэгжилтийн явцад бусад хуулиудыг дагалдан нийтдээ 4 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд бие даасан нэмэлт, өөрчлөлт ороогүй, хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийгээгүй байна.

Иймд ЦАХЭХХтХ-ийн хэрэгжилтийн байдалд судалгаа хийж, цэргийн эд хөрөнгийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд үүссэн хүндрэлтэй асуудал, цэргийн байгууллага, төрийн бусад байгууллага болон ЦАХ хооронд маргаан үүсдэг асуудал, ЗХЖШ-аас зохион байгуулсан хэлэлцүүлэг, санал, асуулгын үр дүнд үндэслэн ЦАХЭХХтХ-ийн зарим зүйл, заалтыг сонгон авч хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх аргачлалын дагуу үнэлж дүгнэхийг зорьсон болно.

3.1. “ЗОРИЛГОД ХҮРСЭН ТҮВШИН” ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮРЭЭНД ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. ЦАХЭХХтХ-ийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан учирсан хохирлыг төлсөн тохиолдолд гарсан зардлыг барагдуулахтай холбоотой зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх.

ЦАХЭХХтХ-ийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан ЦАХ-ийн гуравдагч этгээдэд учруулсан хохирлын хэмжээг хэрхэн тогтоодог эсэх, тухайн цэргийн байгууллагаас барагдуулсан төлбөрийг гэм буруутай ЦАХ-аар нөхөн төлүүлдэг эсэхийг судалж, дүгнэсэн болно.

Цэргийн эд хөрөнгөд учирсан хохирлын хэмжээг тодорхойлох норм, аргачлал тодорхой бус байна.

ЦАХ-ийн буруутай үйлдэл, эс үйлдэхүйг тодорхой болгох, мөн гуравдагч этгээдэд хохирол учирсан тохиолдолд тухайн ЦАХ-аар хохирлыг нөхөн төлүүлэх, цэргийн байгууллагаас ЦАХ-ын буруутай үйлдлийн улмаас учруулсан хохирлыг барагдуулахгүй байх зохицуулалтыг хуульд нарийвчлан тусгаж, эдийн засгийн нөхцөл байдалд нийцүүлэн, нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзэж байна.

3.2. “ПРАКТИКТ НИЙЦЭЖ БАЙГАА БАЙДАЛ” ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮРЭЭНД ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд ЦАХЭХХтХ-ийн дараах зүйл, хэсэг, заалтууд практикт хэрхэн хэрэгжиж байгаа болон хэрэгжилтэд үүсдэг тулгамдсан асуудлыг судлан үзнэ.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. ЦАХЭХХтХ-ийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт заасан тусгай зориулалтын болон зах зээлийн үнийг нь тодорхойлох

боломжгүй эд хөрөнгийн үнийг тодорхойлох зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Тус зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх.

Зэвсэгт хүчний эзэмшилд байгаа, санхүүгийн тайлан бүртгэлд туссан зарим зэвсэглэл, техник, тоног төхөөрөмж, барилга байгууламж нь ашиглалтын хугацаа дууссан, хадгалалтын горим алдагдсан, эд анги нь тоногдсон, үргэлжлүүлэн ашиглах боломжгүй болсон, үйлдвэрлэхгүй болсон, зах зээлд худалдаалдаггүй, зах зээлийн үнийг тодорхойлох боломжгүй, ашиглалтын зардал их гарч байна.

Тусгай зориулалтын болон зах зээлийн үнийг нь тодорхойлох боломжгүй эд хөрөнгийн үнийг Батлан хамгаалахын сайдын тушаалаар батлагдсан Тусгай зориулалтын цэргийн эд хөрөнгийн жагсаалтыг баримталж тогтоодог хэдий ч хэрэв уг жагсаалтад тусгагдаагүй тохиолдолд нягтлан бодох бүртгэлд туссан өртгөөр тодорхойлж байна.

Дээрх жагсаалтад тусгагдаагүй тусгай зориулалтын болон зах зээлийн үнэ нь нягтлан бодох бүртгэлд бага мөнгөн дүнгээр туссан тохиолдолд цэргийн эд хөрөнгийн үнэлгээ буурах эрсдэлтэй байж болзошгүй.

Түүнчлэн цэргийн зарим нэр төрлийн эд хөрөнгө нь зах зээлд нийлүүлэгддэггүй, үйлдвэрлэл нь зогссон байдаг тул зах зээлээс тухайн нэр төрлийн тусгай зориулалтын болон эд хөрөнгийн үнийг тодорхойлох боломжгүй нөхцөл үүсэж байна.

Иймд, хуулийг нэг мөр хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор ЦАХЭХХтХ-ийн 8.2 дахь хэсгийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн өөрчлөн найруулах нь зүйтэй байна. Ингэснээр цэргийн эд хөрөнгийн үнэлгээ нэмэгдэж, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал хангагдана.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 2. ЦАХЭХХтХ-ийн 10 дугаар зүйлийн 10.5-д заасан цэргийн эд хөрөнгийн үлдэгдэл төлбөрийг шүүхийн журмаар төлүүлэхтэй холбогдох зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Тус зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх.

ЦАХ-ийг албан тушаалаас чөлөөлөх, шилжүүлэх, халах, цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгох тохиолдолд тухайн ЦАХ, эсхүл цэргийн байгууллагын холбогдох албан тушаалтнууд эд хөрөнгийн төлбөр тооцоог бүрэн хийдэггүй, тойрох хуудасны хөтлөлтөд тавих хяналт сул, хариуцсан ажил, хүлээн авсан эд хөрөнгийг бүрэн хүлээлцдэггүй зэрэг зөрчил нийтлэг илэрч байна.

ЦАХ-д тавьж олгосон цэргийн дүрэмт хувцас хэрэглэлийн төлбөрийг нөхөн барагдуулахаар шүүхэд нэхэмжлэх, төрийн хөрөнгөөр суралцсан хугацааны зардлыг нөхөн төлүүлэх эрх зүйн зохицуулалтыг хуульд нарийвчлан тусгагдаагүй байна.

Хуулийн дээрх зохицуулалтын хэрэгжилтийг тухайн ЦАХ-д эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэсэн эсэх, төлсөн болон цаашид төлөх төлбөрийн хэмжээний талаарх судалгаа гаргасан эсэх, цэргийн албанаас чөлөөлөгдсөн, эсхүл халагдсан иргэний үлдэгдэл төлбөрийг төлүүлэхээр шүүхэд хандаж шийдвэрлэсэн эсэхийг судална.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 3. ЦАХЭХХтХ-ийн 10 дугаар зүйлийн 10.7-д заасан нөхөн төлөх төлбөрийн хэмжээг багасгах зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ?

Цэргийн анги, байгууллагын захирагч /дарга/ хохирол учирсан нөхцөл байдал, гэм буруугийн хэр хэмжээ болон ЦАХ-ийн эд хөрөнгийн байдлыг харгалзан нөхөн төлөх төлбөрийн хэмжээг багасгахтай холбогдох зохицуулалт нь бусдад давуу байдал бий болгох, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөлийг бүрдүүлэх, улмаар тухайн цэргийн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг алдагдуулах эрсдэлтэй байна.

Иймд, Хууль тогтоомжийн тухай хуульд заасан үндэслэл, журамд нийцүүлэн дээрх зохицуулалтад нэмэлт, өөрчлөлт оруулж, хуулийн хэрэгжилтийг тодорхой, ойлгомжтой болгох шаардлагатай.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, САНАЛ

ЦАХЭХХтХ-ийн зарим зохицуулалтад Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр хавсралтын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ыг үнэлгээ хийв.

Ийнхүү үнэлэхдээ тус хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг баримталж, мөн үнэлгээний хүрээ, онцлогтой уялдуулан аргачлалд заасны дагуу “Зорилгод хүрсэн түвшин”, “Практикт нийцэж байгаа байдал” гэсэн 2 шалгуур үзүүлэлтийг сонгон үнэллээ.

“Зорилгод хүрсэн түвшин шалгуур” үзүүлэлтийн хүрээнд ЦАХЭХХтХ-ийн 5 дугаар зүйлийн 5.4 дахь хэсгийг сонгон судалсан болно.

Харин “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд ЦАХЭХХтХ-ийн 10 дугаар зүйлийн 10.5, 10.7 дахь хэсгийн зохицуулалтыг сонгон авч тус хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэллээ. Тус судалгааны ажлыг гүйцэтгэж, дараах дүгнэлтэд хүрлээ. Үүнд:

1. ЦАХЭХХтХ-ийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасны дагуу ЦАХ-ийн буруутай үйлдлийн улмаас гуравдагч этгээдэд учирсан хохирлыг тухайн байгууллага төлсөн тохиолдолд гарсан зардлыг тухайн буруутай цэргийн алба хаагчаар нөхөн барагдуулах талаар авч хэрэгжүүлсэн ажлын үр дүнг сайжруулах, тухайн хэрэг, маргааныг хууль, шүүхийн байгууллагаас хянан шийдвэрлэх хүртэл хугацаанд гуравдагч этгээдэд учирсан хохирлыг тухайн цэргийн байгууллагаас төлөхгүй байх нь зүйтэй гэж үзэж байна. Цаашид хуулийн зохицуулалтад нэмэлт, өөрчлөлт оруулах замаар ЦАХ-ийн буруутай үйлдлийн улмаас гуравдагч этгээдэд учирсан хохирлыг тухайн ЦАХ-аар төлүүлэхтэй холбогдох зохицуулалтыг тусгах нь шаардлагатай гэж дүгнэж байна.

2. ЦАХЭХХтХ-ийн 10 дугаар зүйлийн 10.5-д заасны дагуу цэргийн эд хөрөнгийн хариуцлага хүлээж, төлбөрөө барагдуулж буй ЦАХ ЦАтХ-д заасан үндэслэлээр цэргийн албанаас чөлөөлөгдсөн, эсхүл халагдсан тохиолдолд үлдэгдэл төлбөрийг төлж барагдуулаагүй бол холбогдох хууль тогтоомжийн дагуу шүүхэд хандаж шийдвэрлүүлж байна. Гэвч бэлтгэл офицер, ахлагч нар үлдэгдэл төлбөрөө төлж барагдуулдаггүй, төлөхөөс зайлсхийх зөрчил нийтлэг байна. Тухайлбал, цэргийн дүрэмт хувцасны төлбөрийн зөрчил дийлэнх хувийг эзэлж байна. Иймд хуульд цэргийн албанаас чөлөөлөгдөх, халагдахаас өмнө үлдэгдэл төлбөрийг төлж барагдуулах, хохирлыг шүүхээр шийдвэрлүүлэхтэй холбогдох зохицуулалтыг нарийвчлан тусгах нь зүйтэй гэж дүгнэж байна.

3. ЦАХЭХХтХ-ийн 10 дугаар зүйлийн 10.7-д заасан цэргийн анги, байгууллагын захирагч, дарга шүүхтэй нэгэн адил хохирол учирсан нөхцөл байдал, гэм буруугийн хэр хэмжээ болон ЦАХ-ийн эд хөрөнгийн байдлыг харгалзан нөхөн төлөх төлбөрийн хэмжээг багасгах зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлж, хохирол учруулсан ЦАХ-ийн ёс зүй, сахилга хариуцлага, ажлын үр дүн, учруулсан эд хөрөнгийн байдал, төрөл, хэмжээг харгалзан шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанаас ялгаатай томъёолох шаардлагатай гэж дүгнэж байна.

Дээрх санал, дүгнэлтийн хүрээнд ЦАХЭХХтХ-д зохих нэмэлт, өөрчлөлтийг оруулснаар хууль тогтоомжийг нэг мөр ойлгож хэрэглэх, хууль тогтоомжийн нийцэл, уялдаа холбоо хангагдах эрх зүйн нөхцөл бүрдэх чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

--oo00oo--